



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

# **ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ**

**2026 оны 7 дугаар сар**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 08 сарын 20  
Улаанбаатар хот

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

## Үзүүлэлт

## Тодорхойлолт\*

|                  |                                                                                                                                                                                                                                                                                                     |
|------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тээсэн ачаа      | Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ. |
| Ачаа эргэлт      | Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.                                                                                      |
| Тээсэн зорчигч   | Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.                                                                                                                                                                                                                            |
| Зорчигч эргэлт   | Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.                                                                                                                                                                                  |
| Шилжүүлсэн тн.км | Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.                                                                                |
| Тээврийн орлого  | Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.                                       |

\*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

### ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА

Л.БАЯНЗУЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГЭРЭЛНЯМ

### БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ<sup>1</sup> бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

<sup>1</sup> Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

## АГУУЛГА

|                                                                           |            |
|---------------------------------------------------------------------------|------------|
| <b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b> | <b>5</b>   |
| 1.1. АЧАА ТЭЭВЭР .....                                                    | 6          |
| 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....                                                 | 7          |
| <b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР .....</b>                                 | <b>8</b>   |
| 2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА .....                                              | 8          |
| 2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....                                           | 8          |
| <b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....</b>                                  | <b>9</b>   |
| 3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА .....                                               | 9          |
| 3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ .....                                            | 10         |
| <b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....</b>                             | <b>111</b> |
| 4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА .....                                           | 11         |
| 4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....                                       | 12         |
| 4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ .....                          | 13         |
| 4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ .....                        | 144        |
| 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ .....                                               | 155        |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|                                                                     |    |
|---------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт..... | 5  |
| Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....                            | 8  |
| Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....                                | 8  |
| Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....                             | 9  |
| Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....                          | 10 |
| Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....                               | 11 |
| Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....                            | 12 |
| Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....                 | 13 |
| Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....               | 14 |
| Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....                                   | 15 |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|                                                                                    |    |
|------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 1. Нийт ачаа тээвэр.....                                                     | 6  |
| Зураг 2. Нийт экспорт.....                                                         | 6  |
| Зураг 3. Нийт импорт.....                                                          | 6  |
| Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....                                                  | 7  |
| Зураг 5. Олон улсад зорчигч.....                                                   | 7  |
| Зураг 6. Орон нутгийн зорчигч.....                                                 | 7  |
| Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....                     | 8  |
| Зураг 8.Төмөр замын ачаа .....                                                     | 9  |
| Зураг 9. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....                         | 10 |
| Зураг 10. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....                                     | 10 |
| Зураг 11. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....                           | 10 |
| Зураг 12. Төмөр замын зорчигч тээвэр.....                                          | 10 |
| Зураг 13. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....                              | 11 |
| Зураг 14. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....                                 | 11 |
| Зураг 15. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....                              | 11 |
| Зураг 16. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....                             | 12 |
| Зураг 17. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....                             | 12 |
| Зураг 18. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....                                | 13 |
| Зураг 19. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....                                     | 14 |
| Зураг 20. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь..... | 14 |
| Зураг 21. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....                                   | 15 |

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>2</sup>

Хүснэгт 1



| №  | Үзүүлэлт                                    | Тээврийн төрөл                       | Хэмжих нэгж       | 2025 он         |                 | 2026 он         |                  | Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/ |
|----|---------------------------------------------|--------------------------------------|-------------------|-----------------|-----------------|-----------------|------------------|-----------------------------------------|
|    |                                             |                                      |                   | 7 дугаар сар    | Өссөн дүн       | 7 дугаар сар    | Өссөн дүн        |                                         |
| 1  | Тээвэрлэсэн ачаа                            | Автотээвэр                           | мян.тн            | 7,118.9         | 47,685.4        | 9,820.8         | 72,020.4         | 51.0%                                   |
|    |                                             | Төмөр зам                            | мян.тн            | 3,853.7         | 24,752.8        | 4,981.5         | 35,802.2         | 44.6%                                   |
|    |                                             | Агаар                                | мян.тн            | 0.7             | 5.3             | 0.9             | 5.6              | 4.7%                                    |
|    |                                             | <b>Нийт ачаа</b>                     | <b>мян.тн</b>     | <b>10,973.4</b> | <b>72,443.6</b> | <b>14,803.2</b> | <b>107,828.2</b> | <b>48.8%</b>                            |
| 2  | Дамжин өнгөрсөн ачаа                        | Төмөр зам                            | мян.тн            | 514.0           | 3,424.4         | 511.3           | 3,413.5          | -0.3%                                   |
| 3  | Ачаа гаргалт /экспорт/                      | Төмөр зам                            | мян.тн            | 1,017.4         | 6,514.5         | 1,057.1         | 7,224.1          | 10.9%                                   |
|    |                                             | Автотээвэр                           | мян.тн            | 6,766.1         | 45,482.2        | 9,376.1         | 69,458.1         | 52.7%                                   |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>мян.тн</b>     | <b>7,783.4</b>  | <b>51,996.7</b> | <b>10,433.2</b> | <b>76,682.2</b>  | <b>47.5%</b>                            |
| 4  | Ачаа оруулалт /импорт/                      | Төмөр зам                            | мян.тн            | 331.5           | 2,086.7         | 284.4           | 2,508.5          | 20.2%                                   |
|    |                                             | Автотээвэр                           | мян.тн            | 352.9           | 2,203.3         | 444.6           | 2,562.3          | 16.3%                                   |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>мян.тн</b>     | <b>684.4</b>    | <b>4,290.0</b>  | <b>729.0</b>    | <b>5,070.8</b>   | <b>18.2%</b>                            |
| 5  | Дотоодод тээвэрлэсэн ачаа                   | Төмөр зам                            | мян.тн            | 1,990.8         | 12,727.1        | 3,128.7         | 22,656.1         | 78.0%                                   |
|    |                                             | Агаар                                | мян.тн            | 0.7             | 5.3             | 0.9             | 5.6              | 4.7%                                    |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>мян.тн</b>     | <b>1,991.5</b>  | <b>12,732.5</b> | <b>3,129.6</b>  | <b>22,661.7</b>  | <b>78.0%</b>                            |
| 6  | Ачаа эргэлт                                 | Автотээвэр                           | сая тн.км         | 7,124.0         | 13,236.2        | 10,064.3        | 18,842.5         | 42.4%                                   |
|    |                                             | Төмөр зам                            | сая тн.км         | 1,937.9         | 12,501.0        | 2,199.8         | 15,368.6         | 22.9%                                   |
|    |                                             | Агаар                                | сая тн.км         | 2.1             | 14.0            | 2.6             | 17.6             | 26.0%                                   |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>сая тн.км</b>  | <b>9,064.1</b>  | <b>25,751.2</b> | <b>12,266.7</b> | <b>34,228.7</b>  | <b>32.9%</b>                            |
| 7  | Зорчигчдын тоо                              | Автотээвэр                           | мян.хүн           | 10,560.2        | 93,007.3        | 11,245.6        | 100,802.5        | 8.4%                                    |
|    |                                             | Төмөр зам                            | мян.хүн           | 167.4           | 1,030.3         | 171.4           | 1,009.3          | -2.0%                                   |
|    |                                             | Агаар                                | мян.хүн           | 293.5           | 1,356.7         | 317.8           | 1,467.9          | 8.2%                                    |
|    |                                             | <b>Нийт зорчигч</b>                  | <b>мян.хүн</b>    | <b>11,021.0</b> | <b>95,394.3</b> | <b>11,734.9</b> | <b>103,279.7</b> | <b>8.3%</b>                             |
| 8  | Олон улсад зорчигчдын тоо                   | Автотээвэр                           | мян.хүн           | 28.5            | 181.4           | 28.6            | 163.4            | -9.9%                                   |
|    |                                             | Төмөр зам                            | мян.хүн           | 5.1             | 26.7            | 4.5             | 22.1             | -17.3%                                  |
|    |                                             | Агаар                                | мян.хүн           | 250.0           | 1,106.0         | 276.2           | 1,224.6          | 10.7%                                   |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>мян.хүн</b>    | <b>283.6</b>    | <b>1,314.0</b>  | <b>309.3</b>    | <b>1,410.1</b>   | <b>7.3%</b>                             |
| 9  | Орон нутагт зорчигчдын тоо                  | Автотээвэр                           | мян.хүн           | 162.2           | 962.6           | 171.8           | 981.2            | 1.9%                                    |
|    |                                             | Төмөр зам                            | мян.хүн           | 162.3           | 1,003.6         | 166.9           | 987.2            | -1.6%                                   |
|    |                                             | Агаар                                | мян.хүн           | 43.4            | 250.7           | 41.7            | 243.3            | -3.0%                                   |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>мян.хүн</b>    | <b>367.9</b>    | <b>2,217.0</b>  | <b>380.3</b>    | <b>2,211.7</b>   | <b>-0.2%</b>                            |
| 10 | Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо | Автотээвэр                           | мян.хүн           | 10,369.4        | 91,863.3        | 11,045.3        | 99,657.9         | 8.5%                                    |
| 11 | Зорчигч эргэлт                              | Автотээвэр                           | сая хүн.км        | 152.9           | 998.6           | 159.9           | 1,009.6          | 1.1%                                    |
|    |                                             | Төмөр зам                            | сая хүн.км        | 66.3            | 424.6           | 67.6            | 421.7            | -0.7%                                   |
|    |                                             | Агаар                                | сая хүн.км        | 662.7           | 3,219.5         | 698.5           | 3,402.5          | 5.7%                                    |
|    |                                             | <b>Нийт</b>                          | <b>сая хүн.км</b> | <b>881.9</b>    | <b>4,642.7</b>  | <b>926.0</b>    | <b>4,833.9</b>   | <b>4.1%</b>                             |
| 12 | Агаарын тээврийн нислэгийн тоо              | Олон улсын хөөрөлт, буултын тоо      | ш                 | 1,841.0         | 8,153.0         | 1,838.0         | 8,853.0          | 8.6%                                    |
|    |                                             | Орон нутгийн хөөрөлт, буултын тоо    | ш                 | 1,931.0         | 6,946.0         | 1,998.0         | 7,186.0          | 3.5%                                    |
|    |                                             | Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо | ш                 | 7,036.0         | 44,645.0        | 8,571.0         | 53,357.0         | 19.5%                                   |

<sup>2</sup> Зам, тээврийн салбарын 2026 оны 07 дугаар сарын статистикийн мэдээг 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдөр гаргав.

## 1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2026 оны 7 дугаар сард 14.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 34.9%-аар өссөн. Харин 2026 оны өссөн дүнгээр нийт 107.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2026 оны 7 дугаар сард 9.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38%-иар өссөн байна. Үүнээс экспортод 9.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 38.6%-иар, импортоор 444.6 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 26%-иар тус тус өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар автотээврээр нийт 72 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 51%-иар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2026 оны 7 дугаар сард 4.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.3%-иар өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар нийт 35.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 44.6%-иар өссөн үзүүлэлттэй байна.
- Агаарын тээврээр 2026 оны эхний 7 дугаар сард 5.6 мянган тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7%-аар өссөн байна.



Экспортоор 2026 оны эхний 7 сард 76.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.5%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 7.2 сая тонн тээвэрлэсэн нь 10.9%-аар, автотээврээр 69.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 52.7%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээврийн ачаа 91%-ийг, төмөр замын ачаа 9%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2026 оны эхний 7 сард нийт 5.1 сая тонн болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.2%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 2.5 сая тонн ачаа импортолсон нь 20.2%-аар, автотээврээр 2.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.3%-аар тус тус өссөн байна. Импортын тээврийн 49%-ийг төмөр замаар, 51%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/





## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2026 оны 7 дугаар сард 11.0 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 %-аар өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар нийт 103.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.3 %-аар өссөн байна.

- Автотээврээр 2026 оны 7 дугаар сард 11.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 6,5 %-иар өссөн байна. Үүнээс орон нутагт 171,8 мянган зорчигч (1,9%), олон улсад 28,6 мянган зорчигч (0,3 %), нийслэлийн нийтийн тээврээр 11,0 сая зорчигч (6.5 %) тус тус зорчсон байна. Эхний 7 сарын байдлаар автотээврээр нийт 103,3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.3 %-аар өссөн байна.
- Төмөр замаар 2026 оны 7 дугаар сард 171.4 мянган зорчигч төмөр замаар зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4%-иар буурсан байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар нийт 1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2%-иар буурсан байна.
- Агаарын тээврээр 2026 оны 7 дугаар сард агаарын тээврээр нийт 317.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3%-иар өссөн байна. Өссөн дүнгээр нийт 1.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.2%-иар өссөн байна.


Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн



Эхний 7 сарын байдлаар олон улсад нийт 1.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 7.3%-иар өссөн байна. Үүнээс агаарын тээврээр 1.2 сая зорчигч (+10.7%), автотээврээр 163.4 мянган зорчигч (-9.9%), төмөр замаар 22.1 мянган зорчигч (-17.3%) тус тус зорчсон байна. Олон улсын нийт зорчигчийн 87%-ийг агаарын тээвэр, 12%-ийг автотээвэр, 1%-ийг төмөр замын тээвэр эзэлж байна. /Зураг 5/

Эхний 7 сарын байдлаар орон нутагт нийт 2,2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0,2 %-иар буурсан байна. Үүнээс автотээврээр 981,2 мянган зорчигч (1,9%), төмөр замаар 987,2 мянган зорчигч (-1,6%), агаарын тээврээр 243,3 мянган зорчигч (-3,0%) тус тус зорчсон байна. Орон нутгийн нийт зорчигчийн 45%-ийг төмөр зам, 44%-ийг автотээвэр, 11%-ийг агаарын тээвэр эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



## БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

## 2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА

2026 оны эхний 7 сард авто замаар 72 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 51%-аар өслөө.


| Үзүүлэлт           | Хэмжих нэгж | 2025 он      |              | 2026 он      |              | Хүснэгт 2<br>Өсөлт<br>бууралтын %<br>2026/2025<br>/Өссөн дүн/ |
|--------------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|---------------------------------------------------------------|
|                    |             | 7 дугаар сар | Өссөн дүн    | 7 дугаар сар | Өссөн дүн    |                                                               |
| <b>Нийт ачаа</b>   | мян.тн      | 7,118,937.1  | 47,685,443.3 | 9,820,779.9  | 72,020,373.3 | 51.0%                                                         |
| <b>Импорт</b>      | мян.тн      | 6,766,052.0  | 45,482,182.4 | 9,376,139.1  | 69,458,058.3 | 52.7%                                                         |
| <b>Экспорт</b>     | мян.тн      | 352,885.0    | 2,203,260.9  | 444,640.8    | 2,562,315.0  | 16.3%                                                         |
| <b>Ачаа эргэлт</b> | сая тн.км   | 1,011.9      | 7,124.0      | 1,288.7      | 10,066.9     | 41.3%                                                         |

2026 оны 7 дугаар сард автотээвэрээр 9.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38%-иар өссөн байна. Үүнээс экспортод 9.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 38.6%-иар, импортоор 444.6 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 26%-иар тус тус өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар автотээвэрээр нийт 72 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 51%-иар өссөн байна.

Автотээврийн ачаа эргэлт 2026 оны 7 дугаар сард 1,288.7 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.4%-иар өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар 10,066.9 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үеэс 41.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Ачаа тээврийн 96%-ийг экспортын ачаа, 4%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа 99.9% эзэлж байгаа бол үүнээс нүүрс 96.7%-ийг эзэлж байна. /Зураг 7/

2026 оны 7 дугаар сард авто замаар 9 сая тонн нүүрс экспортод гарсан. Харин өссөн дүнгээр 67.3 сая тонн нүүрс автозамаар экспортод гарчээ.



## 2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

| Зорчигч тээвэр            | Хэмжих нэгж | 2025 он      |              | 2026 он      |                | Хүснэгт 3<br>Өсөлт<br>бууралтын %<br>2026/2025<br>/өссөн дүн/ |
|---------------------------|-------------|--------------|--------------|--------------|----------------|---------------------------------------------------------------|
|                           |             | 7 дугаар сар | Өссөн дүн    | 7 дугаар сар | Өссөн дүн      |                                                               |
| <b>Нийт зорчигч</b>       | <b>хүн</b>  | 10,560,166.0 | 93,007,338.0 | 11,258,501.0 | 100,737,801.00 | 8.3%                                                          |
| Олон улсад                | хүн         | 28,520.0     | 181,366.0    | 28,604.0     | 163,404.00     | -9.9%                                                         |
| Орон нутагт               | хүн         | 162,207.0    | 962,646.0    | 171,770      | 960,961.00     | -0.2%                                                         |
| Хот доторх нийтийн тээвэр | хүн         | 10,369,439.0 | 91,863,326.0 | 11,045,270.0 | 99,657,855.00  | 8.5%                                                          |
| Зорчигч эргэлт            | сая хүн.км  | 152.9        | 998.6        | 166.2        | 963.61         | -3.5%                                                         |

Автотээвэрээр 2026 оны 7 дугаар сард 11.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5%-иар өссөн байна. Үүнээс орон нутагт 171,8 мянган зорчигч (5.8%), олон улсад 28,6 мянган зорчигч (0.3%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 11,0 сая зорчигч (+1,6 %) тус тус зорчсон байна.

2026 оны эхний 7 сарын байдлаар автотээвэрээр нийт 100,8 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.3%-иар өссөн байна.

Автотээврийн нийт зорчигчийн 98,9%-ийг нийслэлийн нийтийн тээврийн зорчигч, 0.9 %-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.2%-ийг олон улсын зорчигч тус тус эзэлж байна. /Зураг 8/

## БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

## 3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА


Төмөр замын тээврээр 2026 оны эхний 7 сард нийт 35.8 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.6%-аар өслөө.

| Үзүүлэлт                      | Хэмжих нэгж                   | 2025 он      |           | 2026 он      |           | Хүснэгт 4<br>Өсөлт<br>бууралты %<br>2026/2025<br>/өссөн дүн/ |
|-------------------------------|-------------------------------|--------------|-----------|--------------|-----------|--------------------------------------------------------------|
|                               |                               | 7 дугаар сар | Өссөн дүн | 7 дугаар сар | Өссөн дүн |                                                              |
| <b>Ачаа тээвэрлэлт</b>        | <b>мян.тн</b>                 | 3,853.7      | 24,752.8  | 4,981.5      | 35,802.2  | 44.6%                                                        |
| "Улаанбаатар төмөр зам" ХНН   | мян.тн                        | 2,687.1      | 18,636.9  | 2,611.5      | 20,036.9  | 7.5%                                                         |
| "Монголын төмөр зам" ТӨХК     | мян.тн                        | 617.3        | 2,180.8   | 1,323.6      | 8,681.6   | 298.1%                                                       |
| "Монголиантранс Логистик" ХХК | мян.тн                        | 341.9        | 2,279.0   | 683.5        | 2,688.0   | 17.9%                                                        |
| "Монголиантранс Лайн" ХХК     | мян.тн                        | 207.4        | 960.3     | 362.9        | 4,395.7   | 357.8%                                                       |
| Дотоодын ачаа                 | мян.тн                        | 1,990.8      | 12,727.1  | 3,128.7      | 22,656.1  | 78.0%                                                        |
| үүнээс                        | "Улаанбаатар төмөр зам" ХНН   | мян.тн       | 824.2     | 758.7        | 6,890.7   | 4.2%                                                         |
|                               | "Монголын төмөр зам" ТӨХК     | мян.тн       | 617.3     | 1,323.6      | 8,681.6   | 298.1%                                                       |
|                               | "Монголиантранс Логистик" ХХК | мян.тн       | 341.9     | 362.9        | 2,367.4   | 3.9%                                                         |
|                               | "Монголиантранс Лайн" ХХК     | мян.тн       | 207.4     | 683.5        | 4,716.3   | 391.1%                                                       |
| Импорт ачаа                   | мян.тн                        | 331.5        | 2,086.7   | 284.4        | 2,508.5   | 20.2%                                                        |
| БНХАУ-аас                     | мян.тн                        | 81.9         | 529.5     | 67.5         | 680.0     | 28.4%                                                        |
| ОХУ-руу                       | мян.тн                        | 249.6        | 1,557.2   | 216.9        | 1,828.6   | 17.4%                                                        |
| Экспорт ачаа                  | мян.тн                        | 1,017.4      | 6,514.5   | 1,057.1      | 7,224.1   | 10.9%                                                        |
| БНХАУ-руу                     | мян.тн                        | 1,002.8      | 6,417.8   | 1,046.4      | 7,144.1   | 11.3%                                                        |
| ОХУ-руу                       | мян.тн                        | 14.6         | 96.6      | 10.8         | 80.2      | -17.1%                                                       |
| Дамжин өнгөрөх ачаа           | мян.тн                        | 514.0        | 3,424.4   | 511.3        | 3,413.5   | -0.3%                                                        |
| Ачаа эргэлт                   | сая.тн-км                     | 1,937.9      | 12,501.0  | 2,199.8      | 15,368.6  | 22.9%                                                        |


Төмөр замын тээврээр 2026 оны 7 дугаар сард 4.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.3%-иар өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар нийт 35.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 44.6%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл, дотоодын ачаа 22.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 78%-иар, импортын ачаа 2.5 сая тонн болж 20.2%-иар, экспортын ачаа 7.2 сая тонн болж 10.9%-иар тус тус өссөн бол, дамжин өнгөрөх ачаа 3.4 сая тонн болж 0.3%-иар буурсан байна. /Хүснэгт 4/

Зураг 8. Төмөр замын ачаа, мян.тн




**Зураг 9. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь**



2026 оны эхний 7 сарын байдлаар төмөр замаар нийт 35.8 сая тонн ачаа тээвэрлэснээс 20 сая тонн буюу 56%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 8.9 сая тонн буюу 24%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 4.4 сая тонн буюу 12%-ийг "Монголиантранс Лайн" ХХК, 2.7 сая тонн буюу 8%-ийг "Монголиантранс Логистик" ХХК тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 9/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл 22.7 сая тонн буюу 63%-ийг дотоодын ачаа, 7.2 сая тонн буюу 20.0%-ийг экспортын ачаа, 3.4 сая тонн буюу 10%-ийг дамжин өнгөрөх ачаа, 2.5 сая тонн буюу 7%-ийг импортын ачаа тус тус эзэлж байна. /Зураг 10/


**Зураг 10. Төмөр замын ачаа тээврийн төрөл**



Дотоодод тээвэрлэсэн 22.7 сая тонн ачааны 6.9 сая тонн ачаа буюу 30%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 8.9 сая тонн буюу 38%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 2.4 сая тонн ачаа буюу 11%-ийг "Монголиантранс Логистик" ХХК, 4.7 сая тонн буюу 21%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 11/

### 3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

| Үзүүлэлт                  | Хэмжих нэгж    | 2025 он      |           | 2026 он      |           | Хүснэгт 5<br>Өсөлт<br>бууралтын<br>%<br>2026/2025<br>/Өссөн дүн/ |
|---------------------------|----------------|--------------|-----------|--------------|-----------|------------------------------------------------------------------|
|                           |                | 7 дугаар сар | Өссөн дүн | 7 дугаар сар | Өссөн дүн |                                                                  |
| <b>Зорчигч тээвэрлэлт</b> | <b>мян.хүн</b> | 167.4        | 1,030.3   | 171.4        | 1,009.3   | -2.0%                                                            |
| Олон улс                  | мян.хүн        | 5.1          | 26.7      | 4.5          | 22.1      | -17.3%                                                           |
| Орон нутаг                | мян.хүн        | 162.3        | 1,003.6   | 166.9        | 987.2     | -1.6%                                                            |
| Зорчигч эргэлт            | сая хүн.км     | 66.3         | 424.6     | 67.6         | 421.7     | -0.7%                                                            |



2026 оны 7 дугаар сард 171.4 мянган зорчигч төмөр замаар зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4%-иар буурсан байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар нийт 1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2%-иар буурсан байна. Үүнээс олон улсад 22.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 17.3%-иар буурсан бол орон нутагт 987.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.6%-иар буурчээ.


Зорчигч эргэлт 7 дугаар сард 67.6 сая хүн.км болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2%-иар өсжээ. 2026 оны эхний 7 сарын байдлаар 421.7 сая хүн.км болсон нь өмнөх оны мөн үеэс 0.7%-иар буурсан байна. /Зураг 12/

## БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

## 4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 6

| №  | Үзүүлэлт                        | Хэмжих нэгж | 2025 он      |           | 2026 он      |           | Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/ |
|----|---------------------------------|-------------|--------------|-----------|--------------|-----------|-----------------------------------------|
|    |                                 |             | 7 дугаар сар | Өссөн дүн | 7 дугаар сар | Өссөн дүн |                                         |
| 1  | <b>Нийт ачаа, шуудан тээвэр</b> | тн          | 714.5        | 5,338.4   | 912.2        | 5,589.3   | 4.7%                                    |
| 2  | олон улсад                      | тн          | 712.9        | 5,315.9   | 910.2        | 5,563.5   | 4.7%                                    |
| 3  | орон нутагт                     | тн          | 1.6          | 22.6      | 2.0          | 25.8      | 14.1%                                   |
| 4  | <b>Нийт ачаа</b>                | тн          | 703.0        | 5,230.3   | 901.5        | 5,493.3   | 5.0%                                    |
| 5  | олон улсад                      | тн          | 701.4        | 5,207.9   | 899.5        | 5,467.5   | 5.0%                                    |
| 6  | орон нутагт                     | тн          | 1.6          | 22.4      | 2.0          | 25.8      | 15.2%                                   |
| 7  | <b>Нийт шуудан</b>              | тн          | 11.5         | 108.1     | 10.7         | 96.1      | -11.2%                                  |
| 8  | олон улсад                      | тн          | 11.5         | 107.9     | 10.7         | 96.0      | -11.1%                                  |
| 9  | орон нутагт                     | тн          | 0.0          | 0.3       | 0.0          | 0.1       | -80.8%                                  |
| 10 | <b>Ачаа, шуудан эргэлт</b>      | мян.тн-км   | 2,145.3      | 13,993.0  | 2,619.2      | 17,627.5  | 26.0%                                   |
| 11 | олон улсад                      | мян.тн-км   | 2,144.4      | 13,979.1  | 2,617.2      | 17,612.3  | 26.0%                                   |
| 12 | орон нутагт                     | мян.тн-км   | 0.9          | 13.9      | 2.0          | 15.2      | 9.2%                                    |



Агаарын тээврээр 2026 оны эхний 7 дугаар сард 5.6 мянган тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7%-аар өссөн байна. Үүнээс ачаа 5.5 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 5%-аар өссөн бол шуудан 96.1 тонн болж 11.2%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 13/


Олон улсад тээвэрлэсэн ачаа, шуудан 2026 оны эхний 7 сарын байдлаар 5.6 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 4.7%-иар өссөн байна. Харин орон нутагт тээвэрлэсэн ачаа, шуудан 25.8 тонн болж, өмнөх оны мөн үеэс 14.1%-иар өссөн байна. /Зураг 18/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа, шуудангийн 98.0%-ийг олон улсын тээвэр, 2.0%-ийг орон нутгийн тээвэр тус тус эзэлж байна. Мөн нийт ачаа, шуудангийн 98%-ийг ачаа, 2%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2026 оны эхний хагас жилийн байдлаар 17.6 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үеэс 26%-иар өсжээ.



Зураг 15. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




## 4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2026 оны эхний 7 сард нийт 1.5 сая зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 8.2%-аар өслөө.

Хүснэгт 7

| Үзүүлэлт            | Хэмжих нэгж | 2025 он      |             | 2026 он      |             | Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/ |
|---------------------|-------------|--------------|-------------|--------------|-------------|-----------------------------------------|
|                     |             | 7 дугаар сар | Өссөн дүн   | 7 дугаар сар | Өссөн дүн   |                                         |
| <b>Нийт зорчигч</b> | <b>хүн</b>  | 293,464      | 1,356,703   | 317,827      | 1,467,891   | 8.2%                                    |
| Олон улсад          | хүн         | 250,023      | 1,105,957   | 276,172      | 1,224,581   | 10.7%                                   |
| Орон нутагт         | хүн         | 43,441       | 250,746     | 41,655       | 243,310     | -3.0%                                   |
| Зорчигч эргэлт      | мян.хүн км  | 662,727.6    | 3,219,500.5 | 698,502.0    | 3,402,534.2 | 5.7%                                    |
| Олон улсад          | мян.хүн км  | 635,360.8    | 3,074,468.2 | 672,753.0    | 3,258,374.4 | 6.0%                                    |
| Орон нутагт         | мян.хүн км  | 27,366.8     | 145,032.3   | 25,749.0     | 144,159.8   | -0.6%                                   |




2026 оны 7 дугаар сард агаарын тээврээр нийт 317.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3%-иар өссөн байна. Үүнээс олон улсад 276.2 мянган зорчигч зорчиж, өмнөх оны мөн үеэс 10.5%-иар өссөн бол орон нутагт 41.7 мянган зорчигч зорчиж, өмнөх оны мөн үеэс 4.1%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр нийт 1.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.2%-иар өссөн байна. /Хүснэгт 7/

Зорчигч эргэлт 2026 оны 7 дугаар сард 698.5 сая хүн.км болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.4%-иар өссөн байна. Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар 3,402.5 сая хүн.км болж, өмнөх оны мөн үеэс 5.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 17. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар



Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна. /Зураг 17/

## 4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8

| №  | Үзүүлэлт          | 2025 он      |           | 2026 он      |           | Өсөлт<br>бууралтын %<br>2026/2025<br>/өссөн дүн/ |
|----|-------------------|--------------|-----------|--------------|-----------|--------------------------------------------------|
|    |                   | 7 дугаар сар | Өссөн дүн | 7 дугаар сар | Өссөн дүн |                                                  |
| 1  | <b>Олон улсад</b> | 250,023      | 1,105,957 | 276,172      | 1,224,581 | 10.7%                                            |
| 2  | чиглэл Сөүл       | 87,900       | 356,569   | 104,712      | 403,989   | 13.3%                                            |
| 3  | Бээжин            | 35,233       | 176,918   | 42,761       | 196,248   | 10.9%                                            |
| 4  | Токио             | 19,770       | 89,423    | 23,539       | 106,253   | 18.8%                                            |
| 5  | Истанбул          | 16,702       | 80,927    | 15,112       | 79,626    | -1.6%                                            |
| 6  | ХонКонг           | 13,040       | 63,804    | 12,522       | 64,187    | 0.6%                                             |
| 7  | Франкфурт         | 14,982       | 52,890    | 15,013       | 55,946    | 5.8%                                             |
| 8  | Хөх хот           | 5,352        | 31,239    | 8,031        | 51,932    | 66.2%                                            |
| 9  | Бусан             | 12,815       | 44,879    | 11,841       | 32,829    | -26.8%                                           |
| 10 | Эрээн             | 2,925        | 2,925     | 5,723        | 28,459    | 873.0%                                           |
| 11 | Шанхай            | 2,554        | 2,554     | 7,945        | 26,697    | 945.3%                                           |
| 12 | Санья/Хайнань     | 2,554        | 18,577    | 1,669        | 21,656    | 16.6%                                            |


2026 оны эхний 7 сарын байдлаар олон улсын нислэгээр нийт 1.2 сая зорчигч тээвэрлэсэн нь 2025 оны мөн үеэс 10.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Чиглэлээр авч үзвэл Сөүл хотын чиглэл хамгийн өндөр зорчигч урсгалтай хэвээр байгаа бөгөөд 2026 оны эхний 7 сард 403 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.3%-иар өссөн байна. Мөн Бээжин чиглэлд 196 мянган зорчигч зорчиж 10.9%-иар, Токио чиглэлд 106 мянган зорчигч зорчиж 18.8%-иар тус тус өссөн байна.

Европын чиглэлээс Франкфурт чиглэлд 55.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 5.8%-иар өссөн бол Истанбул чиглэлд 79.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.6%-иар буурсан байна.

Зүүн болон Зүүн өмнөд Азийн чиглэлүүдээс Хонконг чиглэлд 64.2 мянган зорчигч зорчиж 0.6%-иар өссөн, Хөх хот чиглэлд 51.9 мянган зорчигч зорчиж 66.2%-иар өссөн, Санья/Хайнань чиглэлд 21 мянган зорчигч зорчиж 16.6%-иар өссөн байна. Дээрх хүснэгтэд хамгийн их зорчигч зорчсон хотуудыг оруулав.

Зураг 18. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр




## 4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

| №  | Үзүүлэлт                          | 2025 он      |           | 2026 он      |           | Өсөлт<br>бууралтын %<br>2026/2025<br>/өссөн дүн/ |
|----|-----------------------------------|--------------|-----------|--------------|-----------|--------------------------------------------------|
|    |                                   | 7 дугаар сар | Өссөн дүн | 7 дугаар сар | Өссөн дүн |                                                  |
| 1  | <b>Орон нутагт зорчигч тээвэр</b> | 43,441       | 250,746   | 41,655       | 243,310   | -3.0%                                            |
| 2  | чиглэл Оюутолгой                  | 29,706       | 206,873   | 26,150       | 190,748   | -7.8%                                            |
| 3  | Ховд                              | 1,768        | 10,219    | 1,668        | 10,818    | 5.9%                                             |
| 4  | Өлгий                             | 2,949        | 10,089    | 3,413        | 10,600    | 5.1%                                             |
| 5  | Улаангом                          | 1,611        | 4,888     | 551          | 3,705     | -24.2%                                           |
| 6  | Улиастай                          | 874          | 3,981     | 566          | 3,955     | -0.7%                                            |
| 7  | Мөрөн                             | 4,079        | 8,589     | 5,156        | 10,591    | 23.3%                                            |
| 8  | Алтай                             | 946          | 4,468     | 417          | 3,111     | -30.4%                                           |
| 9  | Баянхонгор                        |              |           | 413          | 3,189     | -                                                |
| 10 | Бусад                             |              | 131       | 3,321        | 6,448     | 4822.1%                                          |

Зураг 19. Орон нутгийн зорчигч, чиглэлээр




2026 оны 7 дугаар сард орон нутгийн агаарын тээврээр 41.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.1%-иар буурсан байна.

Харин 2026 оны эхний 7 сарын байдлаар орон нутгийн нислэгээр нийт 243.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү бууралтад Оюутолгой чиглэлд 190.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 7.8%-иар буурсан нь голлон нөлөөлсөн байна. /Хүснэгт 9/

2026 оны эхний 7 сарын байдлаар орон нутгийн агаарын тээврээр зорчсон нийт 243.3 мянган зорчигчийн 63% буюу 152.5 мянган зорчигч нь “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 20% буюу 48.8 мянган зорчигч нь “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 15% буюу 37.3 мянган зорчигч нь “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн нислэгээр “МИАТ” ТӨХК-ийн зорчигчийн тоо 0.4%-иар өссөн бол “Аэро Монголиа” ХХК-ийн зорчигчийн тоо 19.8%-иар, “Хүннү Эйр” ХХК-ийн зорчигчийн тоо 1.2%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 20/

Зураг 20. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



## 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 10

| Үзүүлэлт                      | 2025 он         |              | 2026 он         |           | Өсөлт<br>бууралтын %<br>2026/2025<br>/өссөн дүн/ |
|-------------------------------|-----------------|--------------|-----------------|-----------|--------------------------------------------------|
|                               | 7 дугаар<br>сар | Өссөн<br>дүн | 7 дугаар<br>сар | Өссөн дүн |                                                  |
| <b>Нийт нислэгийн тоо</b>     | 10,808          | 59,744       | 12,407          | 69,396    | 16.2%                                            |
| Олон улсын өнгөрөлтийн нислэг | 7,036           | 44,645       | 8,571           | 53,357    | 19.5%                                            |
| Хөөрөлт, буулт                | 3,772           | 15,099       | 3,836           | 16,039    | 6.2%                                             |
| Олон улсын хөөрөлт, буулт     | 1,841           | 8,153        | 1,838           | 8,853     | 8.6%                                             |
| Орон нутгийн хөөрөлт, буулт   | 1,931           | 6,946        | 1,998           | 7,186     | 3.5%                                             |

2026 оны 7 дугаар сард нийт нислэгийн тоо 12.4 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.8%-аар өссөн байна. Өссөн дүнгээр нийт нислэгийн тоо 69.4 мянга болж өмнөх оны мөн үеэс 16.2%-аар өссөн. Үүнээс олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 53.4 мянга болж 19.5%-аар, олон улсын хөөрөлт, буулт 8.9 мянга болж 8.6%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 7.2 мянга болж 3.5%-аар тус тус өссөн байна. /Зураг 21/

Зураг 21. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

